| 210202                | Тэтгэмжийн даатгал                                    | 2,729,200.00          | 2,592,964.02   | 136,235.98      | 95.0  |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                     | 2,183,400.00          | 2,074,511.24   | 108,888.76      | 95.0  |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                  | 545,800.00            | 516,245.05     | 29,554.95       | 94.6  |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                 | 5,458,600.00          | 5,174,192.64   | 284,407.36      | 94.8  |
| 2103                  | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | 67,412,500.00         | 67,336,653.80  | 75,846.20       | 99.9  |

|             |   |                       |                       |               |              |
|-------------|---|-----------------------|-----------------------|---------------|--------------|
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 3,000,000.00          | 2,924,222.00          | 75,778.00     | 97.5         |
| 210302      | Түлш, халаалт   | 46,384,600.00         | 46,384,575.80         | 24.20         | 100.0        |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 5,527,900.00          | 5,527,856.00          | 44.00         | 100.0        |
| 210304      | Байрны түрээс   | 12,500,000.00         | 12,500,000.00         | -             | 100.0        |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                         | <b>235,200.00</b>     | <b>235,200.00</b>     | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал       | 235,200.00            | 235,200.00            | -             | 100.0        |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | <b>33,483,600.00</b>  | <b>33,483,010.00</b>  | <b>590.00</b> | <b>100.0</b> |
| 210502      | Хоол, хүнс  | 33,483,600.00         | 33,483,010.00         | 590.00        | 100.0        |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                        | <b>1,580,000.00</b>   | <b>1,579,975.00</b>   | <b>25.00</b>  | <b>100.0</b> |
| 210604      | Урсгал засвар   | 1,580,000.00          | 1,579,975.00          | 25.00         | 100.0        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | <b>592,000.00</b>     | <b>591,800.00</b>     | <b>200.00</b> | <b>100.0</b> |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 592,000.00            | 591,800.00            | 200.00        | 100.0        |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | <b>10,022,700.00</b>  | <b>10,022,700.00</b>  | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 7,022,700.00          | 7,022,700.00          | -             | 100.0        |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                               | 3,000,000.00          | 3,000,000.00          | -             | 100.0        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>1,801,500.00</b>   | <b>1,801,500.00</b>   | <b>-</b>      | <b>100.0</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                                   | <b>1,801,500.00</b>   | <b>1,801,500.00</b>   | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                         | 1,801,500.00          | 1,801,500.00          | -             | 100.0        |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | <b>436,712,800.00</b> | <b>436,712,800.00</b> | <b>-</b>      | <b>100.0</b> |
| <b>1310</b> | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                  | <b>345,317,300.00</b> | <b>345,317,300.00</b> | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 131001      | Улсын төсвөөс санхүүжих   | 345,317,300.00        | 345,317,300.00        | -             | 100.0        |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | <b>91,395,500.00</b>  | <b>91,395,500.00</b>  | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 132001      | Орон нутгийн төсвөөс  | 91,395,500.00         | 91,395,500.00         | -             | 100.0        |
| <b>61</b>   | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>   | <b>1</b>              | <b>1</b>              | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 610001      | Төсвийн байгууллага   | 1                     | 1                     | -             | 100.0        |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>   | <b>21</b>             | <b>21</b>             | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 620001      | Удирдах ажилтан   | 1                     | 1                     | -             | 100.0        |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан   | 12                    | 12                    | -             | 100.0        |
| 620003      | Үйлчлэх ажилтан   | 8                     | 8                     | -             | 100.0        |
| <b>63</b>   | <b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>                       | <b>150</b>            | <b>150</b>            | <b>-</b>      | <b>100.0</b> |
| <b>631</b>  | <b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>                 | <b>150</b>            | <b>150</b>            | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 631001      | Төрийн өмчит СӨБ байгууллага                                    | 150                   | 150                   | -             | 100.0        |
| <b>65</b>   | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                                      | <b>21</b>             | <b>21</b>             | <b>-</b>      | <b>100.0</b> |
| 650004      | СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)             | 11                    | 11                    | -             | 100.0        |
| 650009      | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                      | 10                    | 10                    | -             | 100.0        |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Булган сумын 4-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасны дагуу хамран тойргийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагаа явуулж хүүхэд нэг бүрийг хамруулах, чанартай боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэйгээр ажилласан байна.

2022 онд “Хүүхэд бүрийн сурах үйл, тэдний хөгжлийг дэмжихэд тулгарч буй бэрхшээлийг арилгахад хамтын оролцоог нэмэгдүүлэх, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй тасралтгүй зохион байгуулж төлөвшлийг олгон хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх” зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хамрах тойргийн хүрээнд байгаа хүүхэд нэг бүрийг сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх
- Хүүхэд бүрийг чанартай сургуулийн өмнөх боловсрол эзэмшихэд туслан эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэн ажиллах
- Багшийн хөгжлийг дэмжиж суралцагч бүрд чанартай сургуулийн өмнөх боловсрол олгож цэцэрлэгийн үйл ажиллагааг сайжруулах

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Боловсролын салбарт болон өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ батлаагүй, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,344.2 мянган төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл    | Эцсийн үлдэгдэл   | Өөрчлөлт           |
|---|-------------------|-------------------|--------------------|
| Б   | 1                 | 2                 | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                 | 1,357.99          | 1,357.99           |
| Авлага  | 6,644.63          | -                 | (6,644.63)         |
| Урьдчилгаа  | -                 | -                 | -                  |
| Бараа материал                                    | 55,361.88         | 53,335.91         | (2,025.97)         |
| Үндсэн хөрөнгө                                    | 141,767.26        | 62,735.65         | (79,031.61)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>203,773.78</b> | <b>117,429.55</b> | <b>(86,344.23)</b> |
| Өр төлбөр   | -                 | 341.90            | 341.90             |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 203,773.78        | 117,087.65        | (86,686.13)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>203,773.78</b> | <b>117,429.55</b> | <b>(86,344.23)</b> |

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь авлага, үндсэн хөрөнгийн данснууд буурсан байна.

Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын тайлант онд тооцоо нийлж барагдуулсан. Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Х/10 дугаар хуралдааны тогтоолоор 118,960.4 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилгыг, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 01 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэж эрхлэгчийн 2022 оны А/10 дугаар тушаалаар 13,583.4 мянган төгрөгийн 24 нэр төрлийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж тус тус акталж, 16,045.5 мянган төгрөгийн 13 нэр төрлийн хөрөнгийн үнийг дахин шинэчлэн тогтоосноос шалтгаалан тайлант хугацааны үр дүн буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 367,520.7 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаар зардлыг 22,203.4 мянган төгрөгөөр бууруулан, 345,317.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 436,712.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 436,712.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 435,278.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,434.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д             | Хөтөлбөр арга хэмжээний |  | Төлөвлөгөө        | Гүйцэтгэл         | Зөрүү           | Биелэлт     |
|-----------------|-------------------------|--|-------------------|-------------------|-----------------|-------------|
|                 | Код                     | Хөтөлбөр арга хэмжээ   |                   |                   |                 |             |
| <b>Нийт дүн</b> |                         |  | <b>436,712.80</b> | <b>435,278.41</b> | <b>1,434.39</b> | <b>99.7</b> |
| 1               | 71801                   | 81605 /эрүүл мэндийг дэмжих/   | 800               | 800               | -               | 100         |
| 2               |                         | 81807 /цэцэрлэгийн хүүхдийн хоол/  | 33,483.60         | 33,483.01         | 0.59            | 100         |
| 3               |                         | 81816 /хүүхдэд ээлтэй сургалтын орчин/                                     | 756.6             | 756.6             | -               | 100         |
| 4               |                         | 81823 /боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх/         | 800               | 800               | -               | 100         |
| 5               |                         | 81834 /боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх/ | 258,594.90        | 258,043.46        | 551.44          | 99.8        |

|   |   |           |           |        |      |
|---|---|-----------|-----------|--------|------|
| 6 | 81835 /сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах/    | 50,882.20 | 50,076.24 | 805.96 | 98.4 |
| 7 | 80111 /төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал/ | 68992.5   | 68916.2   | 76.3   | 99.9 |
| 8 | 80112 нийтлэг үйлчилгээ                           | 22403     | 22402.9   | 0.1    | 100  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын 4-р цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 436,712.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,550.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,913.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 01/21 дугаар албан тоотоор ирүүлсэн.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |     | Биелэлт |     |      |
|----------|------------------------|-----|---------|-----|------|
|          | Тоо                    | Дүн | Тоо     | Дүн | Хувь |
| Зөвлөмж  | 1                      | -   | 1       | -   | 100  |
| Нийт дүн | 1                      | -   | 1       | -   | 100  |

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 4623.0 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 4511.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 112.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

#### **5.2 Албан шаардлага**

1. Тайлант онд төрийн хэмнэлтийг хэрэгжүүлээгүй, бараа материал нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэн бараа материал нөөцлөхгүй алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөх.

#### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой дөрвөн ажил гүйлгээний и-баримтгүй гүйлгээ хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бэлтгэн нийлүүлэгч талын борлуулалтын орлогыг баталгаажуулан и-баримтыг тухай бүр шаардаж, төлбөрийн баримтыг авч хэвших.

## 2. Шилэн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* 2022 онд шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

---

### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга   | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |                |          |              |                                      |                 |   |          |          |
|--|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|--------------|--------------------------------------|-----------------|---|----------|----------|
|  |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                | Зөвлөмж  |              | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                 | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |          |
|  | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн          | Тоо                                  | Албан тушаалтны | Тоо   | Дүн      |          |
| Тайлант онд төрийн хэмнэлтийг хэрэгжүүлээгүй, бараа материал нөөцөлсөн байна.  | 1           | 4,511.0        | -             | -        | 1               | 4,511.0        | 0        | -            | -                                    | -               | -   | -        | -        |
| Анхан шатны баримтын иж бүрдэл дугуу монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой дөрвөн ажил гүйлгээний и-баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. | 1           | 112.00         | -             | -        | -               | -              | 1        | 112.0        | -                                    | -               | -   | -        | -        |
| <b>Дүн</b>   | <b>2</b>    | <b>4,623.0</b> | <b>-</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>4,511.0</b> | <b>1</b> | <b>112.0</b> | <b>-</b>                             | <b>-</b>        | <b>-</b>  | <b>-</b> | <b>-</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |          | Үүнээс        |     |                 |     |          |          |
|--|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|----------|----------|
|  |             |          | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн      | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо      | Дүн      |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |          |               |     |                 |     |          |          |
| Шилэн дансны мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.           | 1           | 0        |               |     |                 |     | 1        | 0        |
| <b>Дүн</b>   | <b>1</b>    | <b>0</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>0</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |          |               |     |                 |     |          |          |
| <b>Дүн</b>   |             |          |               |     |                 |     |          |          |
| <b>Нийт дүн</b>  | <b>1</b>    | <b>0</b> |               |     |                 |     | <b>1</b> | <b>0</b> |